## "ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 12 дугаар сарын 21

Багануур дүүрэг

| № | Үйл ажиллагааны чиглэл | Гүйцэтгэх ажил үйлчилгээ | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| **Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гүйцэтгэл** | | | | |
| **2.2.1. Зорилт 1.** Дүүргийн хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөв, төлөвлөгөө, хяналт шинжилгээнд жендэрийн мэдрэмжтэй арга зүй нэвтрүүлэх, төр, хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн ажилтнуудын жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх | | | | |
| **Хүрэх үр дүн:** Дүүргийн төрийн албан хаагч, ААНБ-ын удирдлага, ажилтнуудын жендэрийн талаарх ойлголт мэдлэг нэмэгдэж, хандлага өөрчлөгдөн бодлого төлөвлөлт, төсөв жендэрийн мэдрэмжтэй болно. | | | | |
| 1. | Төрийн байгууллагын ажиллагсдын Ажил – ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, бэлгийн дарамтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэх | Албан хаагчдын ажил - ар гэрийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлал, бэлгийн дарамтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх талаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган, хэрэгжилтийг хангах | - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Засгийн газрын 218 дугаар тогтоолын дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журманд нэмэлт өөрчлөлт оруулж Газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/06 тушаалаар баталж, нийт ажилтнуудад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- Мөн дээрх журманд заасанчлан албан хаагчдаас ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой санал асуумжийг авсан. Гэр бүлийн хүчирхийлэл болон ажлын байрны бэлгийн дарамтад орсон, өртсөн албан хаагч байхгүй.<br>- Байгууллагын хэмжээнд ямар нэгэн хүчирхийллийн хэлбэр байдаггүй. | 100% |
| **2.2.2. Зорилт 2.** Гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх | | | | |
| **Хүрэх үр дүн.** Иргэдийн дундах жендерийн талаарх хэвшмэл ойлголт өөрчлөгдөж жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдал багасна. | | | | |
| 2. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтын талаар иргэдэд сургалт, сурталчилгааг зохион байгуулах | Нэгдсэн Үндэстний Байгууллагын санаачилгаар жил бүрийн 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрүүдийг "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян" болгон зарласантай холбогдуулан тухайн жилд тэмдэглэн | - Жендэрийн үндэсний хорооноос Монгол цэргийн өдөр буюу 03 дугаар сарын 18-ны өдрийг тохиолдуулан өрнүүлж буй "Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна" аянд байгууллагын албан хаагчид нэгдэн аяны фрем зургийг өөрсдийн хувийн фейсбүк хуудсанд байршуулсан. Аяны логог байгууллагын цахим хуудсанд байршуулсан.<br>- 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр "Би хариуцлагатай жолооч" уриалгыг бэлтгэж байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтийг уриалсан. Мөн өдөр Хуулийн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | өнгөрүүлэх уриан дор аянд идэвхтэй оролцож, мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээх | зөвлөх зам тээврийн осол, аваар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээллийг албан хаагчдад хүргэсэн.<br><br><br>- Байгууллагын эрэгтэй ажилчдын дунд “Эрүүл хоололт-эрүүл амьдрал” сэдэвт сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан.<br>- “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг 2021 онд “Хүчирхийлэл хүн бүрт хамаатай” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан НЗДТГ-аас өгсөн чиглэлийн дагуу “Үйлдлээрээ үлгэрлье” видеог байгууллагын цахим хуудсанд байршуулж ажилласан. Цахим хуудаснаас мэдээллийг үзсэн тоо – 15<br>- Мөн дүүргийн Цагдаагийн хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу “Хүчирхийлэл хүн бүрт хамаатай”, ЦЕГ-ын “Гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс”, “Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс” зэрэг фейсбүүк хуудсанд тавигдсан тус аянтай холбоотой постер, видео зэрэг нийт 99 мэдээлэлтэй албан хаагчид тухай бүр танилцаж, мэдээллийг багцлан байгууллагын цахим хуудсанд байршуулан хэрэгжилтийг хангасан тухай тайланг 12 дугаар сарын 09-ний өдрийн 180 дугаартай албан бичгээр дүүргийн Цагдаагийн хэлтэст хүргүүлсэн.<br>- Байршуулсан мэдээллийн тоо – 25, мэдээллийг үзсэн тоо - 59 | |
| 3. | Ажил олгогч нь ажилтны гэр бүлийн байдалд судалгааг хийж, ар гэрийг тохиромжтой хэлбэрээр дэмжиж, хорт зуршил бүхий ажилтныг эрүүл | Албан хаагчдын гэр бүлийн байдалд судалгаа хийж тохиромжтой хэлбэрээр дэмжлэг үзүүлэх | - Байгууллагын хэмжээнд архи хэтрүүлэн хэрэглэдэг болон тамхи татдаг, дам тамхидалтанд өртсөн албан хаагч байхгүй.<br>- 08 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүл амьдралын зөв дадал хэвшил” сургалтыг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан. Сургалтаар дараах 3 дэд сэдвийг хэлэлцэн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Үүнд:<br>✓ Биологийн идэвхт цаг, зөв хооллохын ач тус<br>✓ Эрүүл амьдралын гол үндэс - дасгал хөдөлгөөний тухай<br>✓ Идэвхтэй амьдралыг бий болгох гол хүчин зүйлс | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | амьдралын зөв дадал хэвшилд шилжихэд дэмжсэн орчин бүрдүүлэх | | - Байгууллагын Нягтлан бодогч Л.Оюунцэцэгийн гэр бүлд эмнэгэл гачигдал тохиолдож байгууллагын зүгээс тэтгэмж олгон дэмжлэг үзүүлсэн.<br>- Манай байгууллагын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 ажилтантай. Тайлант оны хугацаанд цар тахалтай холбогдон гарсан тогтоол шийдвэрийн хүрээнд шаардлагатай тохиолдолд тус ажилтанг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөлөөр ханган ажилласан.<br>- Мөн дээрх шийдвэрийн хүрээнд бага насны хүүхэдтэй албан хаагчдаас гэрээс ажиллах хүсэлтэй ажилтныг Даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн цахимаар ажиллуулсан. | |
| **2.2.4. Зорилт 4.** Дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоог нэмэгдүүлэх замаар хүний хөгжлийг дэмжих | | | | |
| **Хүрэх үр дүн.** Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирч жендэрийн эрх тэгш байдал хангагдана. | | | | |
| 4. | Ажил олгогчийн зүгээс иргэдийг ажилд авах, албан тушаал дэвшүүлэхэд эрэгтэй хүнийг илүүд үзэх хэвшмэл ойлголтыг арилгах, эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн үүрэгтэй нь холбогдуулан ялгаварлахгүй байх, тухайн байгууллагад цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох замаар хүйсийн тэнцвэрт байдлыг хангах | Ажил олгогчийн зүгээс жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажилд авах | Тайлант онд 1 эрэгтэй ажилтныг холбогдох албан тушаалд томилон хүйсийн тэнцвэрт байдлыг хангаж 5 эр, 5 эм нийт 10 ажилтантайгаар Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ нь жендэрийн эрх тэгш байдалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. | 100% |

УЛААНБААТАР ХОТ БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА
ХОТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.БАЯРЦЭЦЭГ